



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.06 № 01/759  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ДОВЧИНДООГИЙН ЧИНЗОРИГ  
ТАНАА**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Довчиндоогийн Чинзоригийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Довчиндоогийн Чинзоригийн ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Довчиндоогийн Чинзоригийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (᠙... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Довчиндоогийн Чинзоригт.

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд.

Хавсралт ᠙ . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

# ХӨВСГӨЛ АЙМГИЙН 2024 ОНЫ ИТХ-ЫН СОНГУУЛЬД ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМАНД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ДОВЧИНДОО ОВОГТОЙ ЧИНЗОРИГ МИНИЙ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## Нэг .Ерөнхий агуулга.

Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Алсын хараа 20:50, Шинэ сэргэлтийн бодлого, хөтөлбөрт түшиглэн сум орон нутгийн онцлог, байгаль цаг уур, хүрээлэн буй орчин, хөдөө аж ахуйд тулгуурласан байгалийн нөөцөд түшиглэсэн, аялал жуулчлалыг дэмжсэн “Органик үйлдвэрлэл бүхий орон нутаг” болно гэсэн эрхэм зорилгыг баримталж , иргэдийн аж байдал, амьдрах орчныг сайжруулахад чиглэнэ.

## Хоёр.Хөтөлбөрийн үндсэн заалт


### Нэг: Өрхийн хөгжлийг дэмжих, орлого нэмэгдүүлэх чиглэлээр

- Мөрөн, Эрдэнэт, Дархан хотын томоохон худалдааны төвүүдэд Чандмань-өндөр сумын бараа бүтээгдэхүүн худалдаалдаг цэг бий болгох чиглэлээр санаачлага гаргана.
- Өрхийн төвшинд хүнсний ногоо, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх, нэр төрлийг олшруулах, сургалт зохион байгуулна
- Орон гэргүй айл өрхүүдийг орон гэртэй болгох ,орон гэргий нөхцөлийг сайжруулахад санаачлагтай ажиллана.
- Мэргэжлийн Ур чадвар олгох урт болон богино хугацааны сургалтуудыг зохион байгуулах

### Хоёр: Хөдөө аж ахуй, байгалийн нөөц ашиглах чиглэлээр

- Засгийн газрын 2022 оны 424 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “ЧАНДМАНЬ” эрүүл бүс хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- Хүнсний ногоо тариалах чиглэлийн сургалт сурталчилгааг зохион байгуулна.
- Байгалийн нөөцийг ʘжимс, самар, ургамалʘ боловсруулах, зах зээлд нийлүүлэх талаар сургалт сурталчилгааны ажлыг хийж, бүтээгдэхүүнийг хадгалах, савлах савлагааны үйлдвэр цехийг бий болгоход бодлогоор дэмжинэ.
- Туслах аж ахуй ʘГахай, тахиа, Зөгийʘ эрхлэх санал санаачилгыг дэмжинэ.
- Иргэдийн оролцоотой Байгаль орчныг хамгаалах уламжлалт арга барилаас суралцах, зөв дадал зан үйл бий болгох олон төрлийн ажил зохион байгуулна.


### Дөрөв: Иргэд олон нийтэд чиглэсэн ажил




З. Д. Д. Д.

0000000001


- Олон улсын төсөл хөтөлбөрт Чандмань-өндөр сумаа хамруулах, иргэдийн амьжиргааг нэмэгдүүлэх, байгаль орчны хамгаалах, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр гаднаас санхүүжилт босгох ажлыг эрчимтэй эрэлхийлнэ.
- Хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, авьяас чадварыг хөгжүүлэх, хүүхдэд ээлтэй орчин нөхцөл бий болгох санал санаачилгыг дэмжинэ. Энэ чиглэлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Сумын төвийн өнгө үзэмжийг сайжруулж, Хашаандаа сайхан амьдарья, Жорлонгоо өөрчилъе, Хогоо багасгая хөдөлгөөнүүдийг сумандаа өрнүүлнэ.



МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН

 Д.ЧИНЗОРИГ

Холбоо барих дугаар: 89807136



0000000000?